

НОХОЙГ АЛБАНД АШИГЛАХ АСУУДАЛ БА ТУРШЛАГА

Б.МӨНГӨНБАГАНА

Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн профессор, докторант, дэд хурандаа

Товч утга: Энэхүү илтгэлд хууль сахиулах байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд албаны нохойг тусгай хөтөлбөрөөр сургаж бэлтгэн албанд ашиглах асуудал ба туршлагын судлан авч үзсэн.

Түлхүүр үгс: аюулгүй байдал, албаны нохой, албаны нохойн сургалт

Abstract:

In this report, the problems and experiences of the use of service dogs by law enforcement agencies, prepared by a special program of training, for the successful fulfillment of their legal obligations.

Keywords: safety, service dog, training service dog

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагууд нь хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд аюулгүй байдлыг хангах, онцгой объектыг хамгаалах, гэмт хэрэг, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хилийн болон хил орчмын дэглэмийг

сахиулах, улсын хилээр болон онцгой объектоор нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа, барааг шалган нэвтрүүлэх зорилгоор албаны нохойг тусгай хөтөлбөрөөр сургаж бэлтгэн албанд ашигладаг.

Албаны нохойг гүйцэтгэх үүргээс нь хамааран эрлийн, харуул хамгаалалтын, тусгай зориулалтын буюу тээврийн хэрэгсэл, ачаа бараа, эд зүйл, хүний биед үзлэг хийх, тэсрэх бодис, хэрэгсэл, мансууруулах бодис, зэвсэг, галт хэрэгсэл илрүүлэх, хууль зөрчигч этгээдийг саатуулах чиглэлээр тусгайлан бэлтгэдэг⁷.

Албанд ашиглах нохойг тусгай шалгуураар сонгон шалгаруулж сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулдаг. Албаны нохойн сургалтыг хоол тэжээлийн хэрэгцээнд үндэслэн явуулснаар богино хугацаанд дадлагажуулж сургах боломж бүрддэг. Нохойнд хоол тэжээл маш чухал байр суурийг эзэлдэг тул анхан шатны чадвар олгох сургалтад хоол тэжээлд үндэслэн сургалтыг зохион байгуулж, нохойны сонирхол, анхаарлыг татахын тулд тухай үүлдрийн нохойны онцлогт тохируулсан дуртай амттан болох мах, бяслаг, хиам зэргийг ашиглаж болно⁸.

⁷ Порядок действий специалиста-кинолога при работе по поиску взрывчатых веществ, оружия и боеприпасов: Учебно-методическое пособие. Ростов-на Дону, 2004.

⁸ Черногор А.С., Гаджимурадов С.Р., Подковка В.Д. Особенности дрессировки

по поиску и обнаружению ВВ, ВУ, оружия и боеприпасов с постановкой сигнального обозначения на комплексный запах: Учебное пособие. Уфа: УШПСК МВД России, 2012.

Албаны нохойнд эрлийн, харуул хамгаалалт, тусгай зориулалтын дадал хэвшлийг суулгахын тулд сургалтыг эхэндээ нохойнд танил орчин нөхцөлд явуулж, түүнд ажиллагааны дарааллыг олон давтамжтайгаар хэвшүүлдэг. Анхан шатны чадвар эзэмшүүлсний дараа танил болсон бодисыг солих, төрөл бүрийн сав, баглаанд өнгөлөн далдлах, өндөрлөг хэсэгт нуух, саад болох дуу чимээ, гэрэлтүүлэгтэй хэсэг, гаднын хүмүүсийн дэргэд, цаг агаарын төрөл бүрийн нөхцөлийг ашиглан гүйцэтгэх даалгаврыг аажмаар хүндрүүлэх шаардлагатай байдаг. Албаны нохойны идэвхийг нэмэгдүүлэхийн тулд илрүүлэх зүйлийн нэр төрөл, байрлалыг сольж, өнгөлөн далдалж, өдөр бүр тогтмол дадлага хийлгэх шаардлагатай.

Онцгой объект, улсын хилээр нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгслийн үзлэгийг замын хаалт, гэрэл дохио, замын тэмдэг, гэрэлтүүлэх хэрэгсэл, тавцан, шат, техник шалгах төхөөрөмжлөгдсөн суваг, тоноглогдсон тусгай төхөөрөмжлөгдсөн талбайд жолооч, тээврийн хэрэгслийг эзэмшигч болон дагалдагч этгээдийг хамт байлцуулан явуулна. Албаны нохой хөтлөгч нь тээврийн хэрэгсэлд үзлэг хийх явцад нохой хуцах, тайван бус байх, самардах, идэвхтэйгээр үнэрлэх, лац гэмтсэн, машины бүхээгийн хучлага урагдсан, сөхөгдсөн, татлага, бэхэлгээ суларсан хэсэг,

автомашины бүтцэд байдаггүй нэмэлт түлшний сав, автомашины дотоод болон гадаад эд ангийн өөрчлөлт, машины бүтцэд хамааралгүй нэмэлт тоног хэрэгсэл нэмэгдсэн зэрэг шинж тэмдгүүдийг нарийвчлан шалгахад онцгой анхаарал хандуулна⁹.

Албаны нохойг ачааны машин, фургон болон чиргүүл, чингэлэгтэй суудлын автомашинд үзлэг хийхэд ашигладаг. Үзлэгийн явцад нохойг богино уяатайгаар удирдах, хэрэв албаны нохой сайн бэлтгэгдсэн бол уяагүйгээр үзлэг, шалгалтад ашиглаж болно. Уяагүй нохой идэвхтэй, чөлөөтэй бие даан үүргээ гүйцэтгэдэг ба нохой хөтлөгч нохойны хөдөлгөөн болон жолоочийн сэтгэл зүйн байдлыг анхааралтай хянах шаардлагатай. Нохойны эрлийн чиглэл нь салхины чиглэлээс хамаарах бөгөөд ихэнх тохиолдолд тээврийн хэрэгслийн арын хэсгээс эхэлдэг. Үзлэгийн явцад нохой хөтлөгч нь албаны нохой автомашины салоныг бохирдуулахгүй, кузовыг самардахгүй, шалгаж буй зүйлийг бохирдуулахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай байдаг.

Автомашинд үзлэг шалгалт явуулах үед автомашины цонх, хаалга заавал онгорхой байх ёстой. Хаалттайгаар явуулсан тохиолдолд албаны нохой автомашины үнэрт дасах эрсдэлтэй. Агаар сэлгэгдэж байгаа тохиолдолд мансууруулах бодис, тэсрэх бодис, зэвсгийн үнэрийг илрүүлэх боломж өндөр байдаг.

⁹ Приказ Министерства транспорта Российской Федерации “Об утверждении правил режима в пунктах пропуска через

государственную границу российской федерации” от 31 марта 2022.

Зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй онцгой объект, хилийн шалган нэвтрүүлэх боомтуудад албаны нохойны ачаалал нэмэгддэг тул хоёр болон түүнээс дээш тооны албаны нохойг ээлжээр үүрэг гүйцэтгүүлдэг. Хэрэв хоёр албаны нохой ашиглагдаж байвал хоёр цагаар ээлжлүүлэн үүрэг гүйцэтгүүлнэ. Эрлийн болон тусгай зориулалтын үнэрч нохой хамт үүрэг гүйцэтгэж байвал хоёр чиглэлээр зэрэг үүрэг гүйцэтгүүлж, үзлэгийн цагийг хэмнэх боломж бүрдэнэ.

Албаны нохойг ашиглаж буй ямар ч ажиллагаа тодорхой хэмжээний эрсдэлийг дагуулдаг тул нохой хөтлөгч албаны нохойтойгоор замын зүүн талаар тээврийн хэрэгслийг тосож хөдөлгөөн үйлдэх, зөвхөн тусгай тогтоосон хэсгээр зам хөндлөн гарах, тээврийн хэрэгслийн бүрэн зогсоож, хөдөлгүүрийг унтраасны дараа үзлэг шалгалтыг эхлүүлэх, жолоочийн эзгүйд, гарын доорх эд зүйл, шалгалтын эвдэрхий хэрэгслээр үзлэг шалгалт явуулах, тээврийн хэрэгслийг налж зогсохыг хориглох зэрэг аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөх шаардлагатай¹⁰.

Үзлэг шалгалтын чиглэлээр албаны нохойг маш сайн бэлтгэж албанд ашигладаг. Тэдний байгалиас заяасан үнэрлэх чадварыг албанд ашигласнаар Хилийн боомтын аюулгүй байдал,

шалган нэвтрүүлэх алба өмнөө тавигдаж буй үүргээ амжилттай биелүүлж, тэсрэх төхөөрөмж, тэсрэх бодис, зэвсэг, сум, галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодисыг онцгой объект, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг таслан зогсоох нөхцөл бүрдэнэ.

Олон улсад хууль сахиулах байгууллагын алба хаагчдын албаны үйл ажиллагаа нь тэдний эрүүл мэнд, амь насанд эрсдэлтэй байдаг тул хууль эрх зүйн хүрээнд албаны нохойг албанд хэрхэн ашиглахыг нарийвчлан зохицуулсан байдаг¹¹. Хууль сахиулах байгууллагад албаны нохой байдаггүй ба хуульд зааснаар хууль сахиулах байгууллагад орон тоогоор бүртгэлтэй албаны нохойг тооцдог туршлага байна.

Орчин үед албаны нохой нь аюулгүй байдлыг цогцоор хамгаалахад чухал үүргийг гүйцэтгэдэг бөгөөд онцгой объектод тогтоосон журам болон улсын хил зөрчигч, гэмт хэрэгтнийг мөрдөн саатуулах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодисыг илрүүлэх, онцгой объектыг хамгаалах, эрлийн болон аврах ажиллагаанд тодорхой үүргийг гүйцэтгэж байна. Аюулгүй байдалд тавигдаж буй шаардлага байнга өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор шинэ төрлийн өндөр чадвартай, тусгай албанд ашиглахад ирээдүйтэй үүлдрийн нохойг нарийвчлан судлан сургаж

¹⁰ Хил хамгаалах албаны аюулгүй ажиллагааны заавар. ХХЕГ. 2006 он.

¹¹ Арипшев А.М. Особенности использования специальных средств

сотрудниками специальных подразделений // Бизнес в законе, 2014. №2. С.301-304

албанд ашиглах шаардлага бий болсон¹².

Израйлын хорих байгууллагын захиргаанаас харуулын нохойн хуцалтад дүн шинжилгээ хийх зарчимд тулгуурлагдсан орчин үеийн дэвшилтэт хамгаалалтын системийг нэвтрүүлсэн туршлагатай. “Bio-Sense Technologies” компаниас хамгаалж буй объектод зөвшөөрөлгүй нэвтэрсэн этгээдийг илрүүлсэн нохойн түгшүүртэй байдалд дүн шинжилгээ хийх зориулалт бүхий “DogGuard” нэртэй программ хангамжийг зохион бүтээсэн. Тус технологи нь онцгой объектыг хамгаалж буй албаны нохойн хүзүүвчинд тусгай зориулалтын дамжуулагч суурилуулан түүний хуцалтад дүн шинжилгээ хийх зарчмаар ажилладаг. Нохойн хуцалтын дууг тусгай микрофоноор бичиж түгшүүртэй, түрэмгий болон айдастай байдалд дүн шинжилгээ хийх зарчмаар ажиллаж, программ хангамж онцгой шинжийг илрүүлсэн тохиолдолд хорих байгууллагын удирдлагын төвд дохио өгдөг. Ийм төрлийн анхны системийг 2005 онд Израйлын 3 хорих байгууллагад суурилуулан ашигласан ба системийг зохион бүтээх болсон шалтгаан нь Израйлын хамгаалалт өндөртэй хорих газраас оргосон тохиолдлуудтай холбоотой юм.

Хорих байгууллагын хамгаалалтад ажиллаж байсан ноход орголт гарсан үед түгшүүрийн дохио өгсөн боловч хамгаалагч нар нь ноход чухам юуг анхааруулаад байгааг ойлгоогүй юм¹³.

Улс орнуудын тусгай албад төрөл бүрийн тусгай ажиллагааны үеэр албаны нохойг ашиглах нь хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэдийгээр техник, технологийн дэвшил чухал ч гэсэн олон тохиолдолд албаны нохойг орлох боломжгүйг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

Орчин үед албаны нохойг албанд үр дүнтэйгээр ашиглах онцлог нь орчин үеийн технологийг тусгайлан сургаж бэлтгэсэн албаны нохойн ур чадвартай нягт уялдуулан ашиглахад оршдог. Мэргэжилтэн, нохой сургагчид албаны нохойд видеокамер суурилуулан аюултай газар оронд үзлэг хийлгэж, өөрөөсөө аюулгүй зайд үзлэг шалгалтыг явуулж нөхцөл байдлыг хяналтдаа байлгах боломжтой болсон.

АНУ-д “Лабрадор”, “Спрингер”, “Кокер-спаниель”, “Немц овчарк”, “Бельгийн Малинуа” үүлдрийн нохдыг албанд түгээмэл ашигладаг. Бүх төрлийн албаны нохой нь онцгой нөхцөлд командаар болон командгүйгээр үүрэг гүйцэтгэхээр бэлтгэгдсэн байдаг. Албаны нохойг ашиглахын

¹² Бякина М.М., Постнов А.В. Правовая основа применения служебных собак как специальных средств в деятельности правоохранительных органов // Аллея науки, 2018. Т.5 №8 (21). С.948-951

¹³ Масленников Е.Е. Отечественный и зарубежный положительный опыт использования собак различных пород на службе в правоохранительных органах и вооруженных силах // Аллея Науки, 2018. Т. 3. №8 (24). С.581-586.

хамгийн гол эерэг шинжид нохойн байгалиас заяасан хурд ордог. Албаны нохой автомашинд зэвсэг, тэсрэх бодис байгаа эсэхийг шалгахад тусгай хэрэгслээр хангагдсан алба хаагчаас богино хугацаанд илрүүлэх боломжтой байдаг.

Японы цагдаагийн албанаас “Той-пудель” үүлдрийн нохойг эрэх ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор албанд сургаж ашиглаж эхэлсэн. Түүний 22-25см жижигхэн бие нь давуу тал болж, том биетэй ноход үүрэг гүйцэтгэх боломжгүй хязгаарлагдмал оронд зайд үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн. Японд албаны ноход хүчтэй газар хөдлөлт болон хар салхины дараа эрэх, аврах ажиллагаанд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг. Японы албаны нохойн холбооноос гаргасан судалгаагаар тус байгууллагад 600000 орчим албаны нохой бүртгэлтэй үүрэг гүйцэтгэж байгаагаас том биетэй “Эрдэльтерьер”, “Боксёр”, “Колли”, “Доберман” үүлдрийн ноход байгаа ба “Немц овчарк” үүлдрийн нохой хамгийн олон буюу 400000 орчим байна.

ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх байгууллага нь албан үүргээ гүйцэтгэхэд “Кавказ овчарк”, “Бельги овчарк”, “Немц овчарк”, “Хар терьер” зэрэг цөөн тооны үүлдрийн нохойг албанд сургаж ашигладаг¹⁴. Нохойг албанд ашиглахын тулд нас, хөдөлгөөн,

биеийн болон булчингийн сайн хөгжил, нервийн систем, сонсгол, шүд, үнэрлэх чадвар сайтай байх, албан үүрэг гүйцэтгэхэд саад болохоор өвчин, сул талгүй байх зэрэг олон шаардлагын дагуу сонгон шалгаруулдаг. ОХУ-ын хууль, хүчний байгууллагуудаас Холбооны ял эдлүүлэх байгууллагын албаны нохойн сургалтын алба нь хамгийн томд тооцогддог бөгөөд 12684 албаны нохой хөтлөгч, 21968 албаны нохойтой гэсэн судалгаа байдаг. Хоногт дунджаар байгууллагын болон объектын хамгаалалтад хүч нэмэгдүүлж 9228 харуулын байранд 543,2км хэсгийн хамгаалалтад албаны ноход үүрэг гүйцэтгэдэг¹⁵.

ОХУ-ын Дотоод хэргийн яамны нохойн сургалтын албанд “Немц овчарк”, “Ротвейлер”, “Спаниель” зэрэг үүлдрийн нохойг албанд ашиглахыг зөвшөөрдөг. Харин “Лабрадор-ретривер” үүлдрийн нохойг гадаадын бусад орны нохойн сургалтын албанаас мансууруулах бодисыг илрүүлэхэд хамгийн өндөр чадвартай гэж зөвлөдөг тул эдгээр 4 үүлдрийн нохойг туршилтад оруулж, байгалийн онцлог, үнэрлэх чадварын онцлогийг 10 жилийн хугацаанд судалсан. Судалгааны үр дүнд “Ротвейлер” үүлдрийн нохой нь хөндлөнгийн этгээдийн дэргэд илүү догшин авир гаргах хандлагатай, “Спанель” үүлдрийн нохой нь эрлийн ажиллагааны үед

¹⁴ Об организации Наставления по организации кинологической службы Федеральной службы исполнения наказаний: Приказ ФСИН России от 29.04.2005 г. №336.

¹⁵ Ширяев Д.С., Шуманский И.И. Применение служебных собак в учреждениях и органах Федеральной службы исполнения наказаний России., УДК 348.847., 2019г.

команд сонсохгүй, муу удирдагддаг зэрэг онцлог шинж ажиглагдсан нь эрлийн ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлөх шалтгаан тул цаашид энэ чиглэлээр ашиглах боломжгүй болохыг харуулсан байна. Харин “Немц овчарк”, “Лабрадор” үүлдрийн нохой нь илүү бие даасан байдалтай байсан нь мансууруулах бодисыг илрүүлэхэд нохой хөтлөгчөөс алслагдсан зайд бие үүрэг гүйцэтгэдэг онцлогт нь илүү тохирч байсан байна. Тайван нөхцөлд дээрх үүлдрийн нохдын үнэрлэх чадварыг ольфактометр багажийн тусламжтайгаар судалж үзэхэд “Лабрадор”-ын үнэрлэх чадварын коэффициент “Немц овчарк” үүлдрийн нохойноос 32 хувиар өндөр гарсан байна¹⁶. Албаны нохойн сургалт өндөр хөгжсөн Австри, Дани, Франц, Герман улсуудад “Бельгийн малинуа” үүлдрийн нохойг шилдгээр тодорхойлсон байдаг¹⁷. Энэ үүлдрийн нохойг АНУ, Канадын хууль сахиулах байгууллагуудад өргөнөөр ашигладаг.

Германы нохойн албанаас Ганноверийн Мал эмнэлгийн дээд сургуультай хамтран 2021 оноос ер бусын төсөл санаачлан хэрэгжүүлсэн байна. Төсөлд зориулан үнэрлэх чадвар өндөртэй “Немц овчарк”, “Кокер-спаниель”, “Ретривер” зэрэг үүлдрийн 10

нохойг сонгон авч коронавирусыг илрүүлэх чадварт сургах туршилт хийжээ. Судалгааны үр дүнд ноход коронавирусыг 80 гаруй хувьтай илрүүлсэн нь нохой сургагчдыг гайхшируулсан үзүүлэлт болсон. Ийм төрлийн судалгааг АНУ, Франц, Их Британи, Финляндад зэрэг эхлүүлсэн байдаг. Эдгээрээс Хельсинкийн их сургуулиас коронавирусын халдвар авсан хүнээс авсан биоматериалын молекулын онцгой бүтцээр нь нохой ялган таних чадвартай болохыг анхлан таамагласан.

Саяхан Германы вирус судлаачид COVID-19-тэй холбоотой судалгаа хийх шаардлагагүй гэж үзэж байсан бол вирусийг химийн хувьд аюулгүй болгож, тусгай төхөөрөмжийн тусламжтайгаар албаны нохдыг сургаж эхэлсэн боловч практикт хэрхэн нэвтрүүлэх, тестийг хэрхэн орлуулах арга замыг олж тогтоож чадаагүй байна. Магадгүй зарим хүмүүс нохойгоор шинжлүүлэхийг зөвшөөрөхгүй байх магадлалтай юм. Германд эрүүл мэндийн чиглэлээр ашигладаг албаны нохой маш цөөн байдаг боловч ирээдүйд албаны нохой эмнэлгийн зориулалттай шалгах багажтай хамтран спортын клуб, нисэх онгоцны буудал зэрэг газруудад бактерийн халдвар илрүүлэх

¹⁶ Лукашев С.А. Опыт зарубежных стран в области организации деятельности по охране общественного порядка со служебными собаками. 2021.

¹⁷ Астахова Л.А. Пойск и обнаружение наркотических и психотропных веществ в учреждениях

УИС-одна из важнейших задач кинологической службы ФСИН России// Ведомости уголовно-исполнительной системы, 2010, №12. С. 30-34 с

чиглэлээр үүрэг гүйцэтгэхийг үгүйсгэх боломжгүй юм¹⁸.

Дүгнэлт:

Хууль сахиулах байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ сайтар сургаж бэлтгэсэн албаны нохойг ашигласнаар аюулгүй байдлыг хангах, онцгой объектыг хамгаалах, гэмт хэрэг, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улс хилээр болон онцгой объектоор нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа, барааг шалган нэвтрүүлэх чадамжаа нэмэгдүүлэх боломжтой юм.

Дэлхийн улс орнууд байгалийн онцлог чадварыг нь судлан “Немц овчарк”, “Кавказ овчарк”, “Бельги овчарк”,

“Лабрадор”, “Спрингер”, “Кокер-спаниель”, “Бельгийн Малинуа” “Эрдэльтерьер”, “Боксёр”, “Колли”, “Доберман”, “Хар терьер” зэрэг олон үүлдрийн нохдыг тусгайлан бэлтгэж албанд ашиглаж, тодорхой үр дүнг өгсөөр байгаа нь цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагыг бий болгож байна.

Санал:

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагуудад албаны нохойг сургаж бэлтгэж байгаа чиглэл, ашиглаж буй үр дүнтэй туршлагуудыг харилцан судалж, хамтарсан сургалт зохион байгуулж албаны нохойн сургалт, албанд ашиглалтыг сайжруулах саналыг дэвшүүлж байна.

¹⁸ Служебных собак бундесвера научать распознавать коронавирус //URL: <https://rg.ru>

Эх сурвалж:

1. Порядок действий специалиста-кинолога при работе по поиску взрывчатых веществ, оружия и боеприпасов: Учебно-методическое пособие. Ростов-на Дону, 2004.
2. Черногор А.С., Гаджимурадов С.Р., Подковка В.Д. Особенности дрессировки по поиску и обнаружению ВВ, ВУ, оружия и боеприпасов с постановкой сигнального обозначения на комплексный запах: Учебное пособие. Уфа: УШПСК МВД России, 2012.
3. Приказ Министерства транспорта Российской Федерации “Об утверждении правил режима в пунктах пропуска через государственную границу российской федерации” от 31 марта 2022.
4. Хил хамгаалах албаны аюулгүй ажиллагааны заавар. ХХЕГ. 2006 он.
5. Арипшев А.М. Особенности использования специальных средств сотрудниками специальных подразделений // Бизнес в законе, 2014. №2. С.301-304
6. Бякина М.М., Постнов А.В. Правовая основа применения служебных собак как специальных средств в деятельности правоохранительных органов // Аллея науки, 2018. Т.5 №8 (21). С.948-951
7. Масленников Е.Е. Отечественный и зарубежный положительный опыт использования собак различных пород на службе в правоохранительных органах и вооруженных силах // Аллея Науки, 2018. Т. 3. №8 (24). С.581-586.
8. Об организации Наставления по организации кинологической службы Федеральной службы исполнения наказаний: Приказ ФСИН России от 29.04.2005 г. №336.
9. Ширяев Д.С., Шуманский И.И. Применение служебных собак в учреждениях и органах Федеральной службы исполнения наказаний России., УДК 348.847., 2019.
10. Лукашев С.А. Опыт зарубежных стран в области организации деятельности по охране общественного порядка со служебными собаками. 2021.
11. Астахова Л.А. Пойск и обнаружение наркотических и психотропных веществ в учреждениях УИС-одна из важнейших задач кинологической службы ФСИН России// Ведомости уголовно-исполнительной системы, 2010, №12. С. 30-34 с
12. Служебных собак бундесвера научать распознавать коронавирусы //URL:<https://rg.ru>